



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 03

Арвайхээр


Шагналд уламжлах тухай

Төрийн албаны зөвлөлийн “Журам батлах тухай” 2013 оны 71 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр шагнах журмын 3.2, “Тав” дахь заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Салбар зөвлөлийн 2018 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хоёрдугаар хуралдааны шийдвэрийг үндэслэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Даваанямын Нэмэхбаяр, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны ахлах мэргэжилтэн Буухүүгийн Балжинням, Стандарт хэмжил зүйн хэлтсийн баталгаажуулалтын албаны дарга Дүгэрсүрэнгийн Байгальмаа, Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч Бат-Очирын Загдзэсэм, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн Юндэнгийн Нямсүрэн, Зүүнбаян-Улаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга Цэрэгийн Одонжаргал нарыг “Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр шагнуулахаар Төрийн албаны зөвлөлд уламжилсугай.

2. “Төрийн албаны тэргүүний ажилтан” тэмдгээр шагнуулах дээрх төрийн албан хаагчдын шагналын материалыг журмын дагуу бүрдүүлж, Салбар зөвлөлийн хуралдааны тэмдэглэлийн хамт Төрийн албаны зөвлөлд хүргүүлэхийг Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга (Э.Бадамгэрэл)-д даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНБОЛД

013100005